

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХОТЫН ДАРГА
НАРЫН ФОРУМД ОРОЛЦОГЧ
ХОТЫН ДАРГА НАРТ

Урилга хүргүүлэх тухай

Эрхэм хүндэт хотын дарга Танаа,

Юуны өмнө миний бие нийслэлийн иргэдийн нэрийн өмнөөс болон хувиасаа танд болон танай иргэдэд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Зүүн хойд Азийн бүсийн хотуудын өмнө тулгарч буй нийтлэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Зүүн хойд Азийн хотуудын дарга нарын анхдугаар форумыг 2014 онд санаачлан зохион байгуулснаас хойш тус форумыг хоёр жил тутам амжилттай зохион байгуулж ирснийг та бүхэн мэдэх билээ.

Зүүн хойд Азийн Хотын дарга нарын 6 дахь удаагийн форумыг энэ оны 08 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо “Зүүн хойд Азийн хотуудын тогтвортой хөгжил: Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин өргөжүүлэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулахыг танд дуулгахад таатай байна. Энэхүү сэдвийн зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангахад дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүч, нийтийн тээвэр, хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт, аялал жуулчлал зэрэг салбарын хүрээнд хотуудын тогтвортой хөгжлийн төлөөх төр, хувийн хэвшлийн түншлэлийн туршлагаас харилцан суралцах юм.

Иймд эрхэм хотын дарга таныг Зүүн хойд Азийн Хотын дарга нарын 6 дахь удаагийн форумд оролцохыг урьж байгааг минь хүлээн авна уу. Эрхэм хотын дарга болон таныг дагалдан ирэх 2 хүртэлх төлөөлөгчдийн (3 шөнө, 4 өдөр) Улаанбаатар хотод байх зардлыг бид хариуцах болсныг дуулгахад таатай байна. Таны оролцоо Зүүн хойд Азийн хотуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Иймд эрхэм хотын дарга таныг тус форумд оролцох эсэхээ 2024 оны 06-р сарын 21-ний дотор хавсаргасан маягтыг бөглөж, Зүүн хойд Азийн Хотын дарга нарын нарийн бичгийн газарт secretariat@neamf.org ирүүлнэ үү.

Энэ завшааныг ашиглан Зүүн хойд Азийн Хотын дарга нарын форумын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж ирсэн танд талархаж байгаагаа илэрхийлье.

Зүүн хойд Азийн Хотын дарга нарын 6 дахь удаагийн форумын урьдчилсан хөтөлбөр, форумын агуулга, маягтыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА,
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР